

## МОНГОЛ-ЯПОНЫ СОЁЛЫН ХАРИЛЦААНЫ ТҮҮХЭН ТОЙМ

*Б.Боргилмаа<sup>1</sup>*

**Abstract:** *Letter Mongolian-Japanese diplomatic relations between the two countries and the history of the history of the first Mongolian-Japanese cultural relations establishment of the cultural agreement periods, and since 1990, features Mongolian-Japanese cultural relations between the Mongolian-Japanese education, culture and scientific documents on cooperation visits and wrote this article based on the preservation and use of materials, politics, economics, archeology and cultural heritage.*

**Товч агуулга:** *Монгол - Япон хоёр орны дипломат харилцаа тогтоосон түүхийн тухай болон соёлын гэрээ байгуулснаас эхлээд Монгол-Японы соёлын харилцааны түүхэн үеүд, мөн 1990 оноос хойших Монгол-Японы соёлын харилцааны онцлог, Монгол-Японы хоорондын боловсрол, соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааны тухай баримт бичиг, айлчлалууд, улс төр, эдийн засаг, археологи, соёлын өвийн хадгалалт ба ашиглалтын материалд тулгуурлан энэхүү өгүүлэлээ бичлээ.*

**Түлхүүр үг:** *Монгол-Японы түүхэн харилцаа, соёлын харилцаа*

Монгол Япон хоёр улсын соёлын харилцаа нь орчин цагийн олон улсын харилцааны чухал асуудлуудын нэг юм. Зөөлөн хүчийг ашиглаж хоёр улсын хоорондын соёлын дипломат ажиллагааг хөгжүүлэх нь зардал багатай бөгөөд үр ашигтай байх талтай. Энэхүү өгүүлэлд Монгол-Японы соёлын харилцааны түүхэн үе, 1990 оноос

---

<sup>1</sup> МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбарын Ази судлалын тэнхим

хойших Монгол-Японы соёлын харилцааны онцлог, Монгол-Японы хоорондын боловсрол, соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааг авч үзлээ. Ингэхдээ баримтад үндэслэн гэрээ хэлцэл, статистик мэдээлэлд анализ хийн, харьцуулалт хийх зэрэг аргыг ашиглан хоёр орны соёлын харилцааны түүхэн замнал, технологийн нээлт, хоёр улсын хоорондын соёлын зарим уулзалтаас ишлэн оруулсан болно.

1960-аад оны эхэн үеэс хоёр улсын дипломат харилцаа тогтоох үйл явц эрчимжиж, багагүй цаг хугацаа, саад бэрхшээлийг давсаны үндсэн дээр анхны нот бичгээ солилцож байжээ. Албан ёсны дипломат харилцаа тогтооход дайны төлбөрийн асуудал болон тухайн үед ОХУ (ЗХУ)-аас манай улс тодорхой хэмжээгээр хараат байсан нь нөлөөлсөн байна. “1960-аад оны эхэн үед хоёр орны хооронд худалдаа, эдийн засгийн харилцаа нэгэнт тогтож, жилээс жилд өргөжсөөр байв. Хоёр улсын Гадаад явдлын яамд, эрдэм шинжилгээний байгууллага, Найрамдлын нийгэмлэг, Улаан загалмайн нийгэмлэг зэрэг олон нийтийн байгууллагуудын шугамаар яриа хэлцэл хийж холбоо харилцаа тогтоож байлаа”.(Б.Сэржав, 2001:3) “1961 оны 10 дугаар сарын 1-ний өдөр Улаанбаатар хотноо Япон улсын Засгийн газраас томилогдсон анхны элч Гаага дахь Японы Элчин Сайдын Яамны (ЭСЯ) гуравдугаар нарийн бичгийн дарга Мүтоо, Москва дахь Японы ЭСЯ-ны гуравдугаар нарийн бичгийн дарга Акихо нар дипломат айлчлал хийжээ.” (Б.Сэржав, 2001:6). Хоёр орны харилцааг хэвийн болгох яриа хэлэлцээр 1965 оныг хүртэл түр завсарласан байна.

“Дайны төлбөрийн асуудлыг дипломат харилцаа байгуулсны дараа, хөрөнгө оруулалт, буцалтгүй тусламжаар шийдэж болно гэж хоёр тал үзсэний үндсэн дээр 1972 оны 2 дугаар сарын 24-ны өдөр дипломат харилцаа тогтоожээ” (Л.Хайсандай, 1998:31). Ийнхүү 1972 онд дипломат харилцаа тогтоосноос хойш Монгол-Японы харилцаа эхний 10 жилийн хугацаанд маргаантай байсан асуудлыг харилцан ойлголцсоны үндсэн дээр хоёр тал шийдвэрлэсэн байна. Харин дараагийн 10 жилийн хугацаанд Японы тал дипломат харилцааг хөгжүүлэх сонирхолтой байсан хэдий ч “Монгол Улс социалист орнуудтай, тэр дундаа ЗХУ-тай хамтран ажиллах ганц сувагтай, түүнээс цааш гарах замгүй, ЗХУ-аас хэт хараат байсан учир Японтой хэлхээ холбоогоо өргөтгөж чадахгүй, бараг ёс төдий харилцаж

байв” (Ц.Батбаяр, 2012:165) хэмээн элчин сайд асан С.Дамбадаржаа тэмдэглэсэн байдаг.

Монгол улс Элчин сайдын яамаа 1973 оны 12 дугаар 24-ны өдөр Токио хотод нээж, анхны элчин сайдаар С.Дамбадаржаа томилогдон 1974 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Япон улсын эзэн хаан Хирохитод итгэмжлэх жуух бичгээ барьж байжээ. “БНМАУ, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосноор БНМАУ болон Японы ард түмний хооронд найрсаг харилцаа, хамтын ажиллагаа бүх талаар өргөжин хөгжиж түүхэн таатай боломж үүссэн” (Б.Сэржав, 2003:44) байна.

/1997 оноос хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа “иж бүрэн түншлэл”-ийн зарчимд тулгуурлан хөгжиж ирсэн байна. Монгол улсад шинэчлэл өрнөж эрх чөлөө, ардчиллын үнэт зүйлийг эрхэмлэсэн нийгэм байгуулж, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж эхэлсэн бөгөөд 1990-ээд оны эхэн үеэс Монгол, Японы хамтын ажиллагаа үсрэнгүй хөгжих суурь тавигдсан юм. Тухайлбал 1990 онд Худалдааны хэлэлцээр, 1991 онд Найрамдал хамтын ажиллагааны гэрээ, 1993, 1994 онд Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулагдаж, 1996 онд Монгол-Японы дипломат харилцааг “иж бүрэн түншлэл”-ийн түвшинд хөгжүүлэх зарчмыг тохиролцсон байдаг. Энэ хүрээнд 2001 онд Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр, 2002 онд Монгол Улсын соёл болон боловсролын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Японы Засгийн газраас үзүүлж буй тусламжийн тухай солилцсон нот, 2003 онд Техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулагдсан байна.

Японы Засгийн газар нь Монгол улстай дипломат харилцаа тогтоосноос хойш өнөөг хүртэл төрөл бүрийн салбарт эдийн засгийн тусламж дэмжлэгийг үзүүлж ирсэн бөгөөд “2015 оны 3 дугаар сарын байдлаар нийт тусламжийн дүн 238 тэрбум иен ([www.mn.emb-japan.go.jp](http://www.mn.emb-japan.go.jp)) -д хүрээд байна. Ийнхүү Япон улс нь Монгол улсад тууштай дэмжлэг үзүүлж ирсэн ба энэ нь Монгол улсын ардчилсан нийгэмд шилжих явцад тулгарсан эдийн засаг, санхүүгийн хүндрэлтэй он жилүүдэд томоохон үүргийг гүйцэтгэж, Монгол улсыг цаашид авч явах хүүхэд залуусын боловсролыг дэмжихэд чиглэгдэж ирсэн билээ.

Харин 2010 оны 11 дүгээр сард Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Япон Улсад төрийн айлчлал хийх үеэр хоёр орны харилцааг цаашид шат ахиулан хөгжүүлэх тухай “Стратегийн түншлэл байгуулахад чиглэсэн Монгол, Японы Хамтарсан мэдэгдэл”-д гарын үсэг зурсан (Б.Сэржав, 2016:28)-аар хоёр орны харилцааг цаашид:

1. Өндөр дээд хэмжээний яриа хэлэлцээг идэвхжүүлэх.
2. Эдийн засгийн харилцааг идэвхжүүлэх, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх.
3. Хүн солилцоо, соёлын харилцааг идэвхжүүлэх.
4. Бүс нутаг, глобал асуудлаар хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг зорилт тавин харилцаа хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

Мөн хамтарсан мэдэгдлийн үеэр японы талын хоёр орны гадаад хэргийн сайд нарын уулзалтыг жил бүр зохион байгуулах тухай саналыг манай улс талархан хүлээн авчээ. Хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг эрчимжүүлж, иргэдийн харилцан зорчих нөхцлийг хөнгөвчлөх зорилгоор Монгол Улсын Засгийн газар 2010 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн япон улсын иргэд манай улсад 30 хүртэл хоногийн хугацаанд визгүй зорчуулах шийдвэр гарсан. Харин Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын иргэдэд 3 хүртэлх жилийн хугацаатай (нэг удаа 15 хүртэлх хоног) “Богино хугацааны олон удаагийн виз” олгох шийдвэрийг 2015 оны 8 дугаар сарын 15-наас эхлэн мөрдсөн. ([www.mfa.gov.mn](http://www.mfa.gov.mn)) Манай хоёр улс ерөнхийдөө эдийн засаг, бүтээн байгуулалт, соёл боловсрол талаараа илүү хамтарч ажилладаг. Мөн Монгол Улс нь түүхэндээ анх удаа Япон улстай эдийн засгийн түншлэл байгуулсан юм.

### **Монгол-Японы соёлын харилцааны түүхэн үе**

Монгол-Японы Соёлын хамтын ажиллагаа тогтоохоос өмнө хэд хэдэн удаагийн уулзалтыг хийсэн байдаг. Тухайлбал “1973 оны 10 дугаар сарын 24-ний 15 цагт Японы Элчин Сайдын Яамны (ЭСЯ) зөвлөх ноён Сакияма Гадаадтай соёлоор харилцах хэлтсийн (ГСХХ) дарга Д.Цэрэндоржтой өөрийн хүсэлтээр ирж уулзжээ. Энэ үед соёлын харилцаа тогтоох саналыг тавьж ирсэн байна. (ГХЯ, 3) Мөн тухайн үед Японы ЭСЯ-ны зөвлөх Сакияма Монголын ард түмэнд болон

дипломат корпусынханд үзүүлэх киног авчирч санал тавьж байсан байна. Харин манайхаас киног Соёлын Яам хянаж үзээд болохоор бол нийтэд үзүүлнэ” хэмээн хариу өгч байжээ. 1974 оны 2 дугаар 18-ны өдөр ГСХХ-ийн дарга Д.Цэрэндорж Японы Элчин Сайд Итару Цугэг урьж уулзан 2 талын соёлын хэлэлцээрийн нот солилцох талаар болон уг нот бичигт юуг тусгаж оруулах тухай тохиролцжээ. (ГХЯ, 14)

Нотны төсөл гардуулсан тухай:

Японы элчин сайд Итару Цугэг-д Монгол-Японы соёлын харилцаа тогтоох тухай өөрийн нот бичгийн төслийг гардуулахдаа зарчмын хувьд 3 ялгаатай зүйл байгааг тусгажээ. Үүнд:

1. Танай төслийн I-р зүйлд “соёлын харилцаа тогтоох” гэж байсныг “соёл, шинжлэх ухаан, техникийн” хэмээн өөрчилсөн.
2. Төслийн 3-р зүйлд “Хувийн байгууллага болон хүмүүсийн хооронд соёлын солилцоо хийхийг зөвшөөрнө” хэмээн орсныг “Засгийн газрын бус байгууллага” гэж оруулсан.
3. Танай төсөлд “Уг нот 2 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна” гэснийг “соёлын харилцаагаар хамтран ажиллах хэлэлцээр байгуулах хүртэл хүчин төгөлдөр” (ГХЯ, 25) байхаар хийжээ.

Мөн соёлын харилцааны хэлэлцээрийн нот бичгийн төслийн үеэр 3 үе шаттай ярилцан Японы тал 3 зүйлийг дахин өөрчилжээ. Ийнхүү 1974 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр БНМАУ, Япон улсын хооронд соёлын харилцаа тогтоосон тухай нот бичгийг БНМАУ-ын Гадаад Явдлын Яаманд ГСХХ-ийн дарга Д.Цэрэндорж, Япон улсаас тус улсад суугаа Онц бөгөөд бүрэн Эрхт Элчин Сайд Итару Цугэ нар солилцжээ.(хэлэлцээр англи хэл дээр хийгдсэн болно.) Энэхүү нот бичгийг солилцсоор оюутан, аспирант, мэргэжил дээшлүүлэгч, хэлний багш нарыг солилцох, кино, үзэсгэлэн, урлагийн хүмүүсийг харилцан илгээх зэргээр хамтран ажиллах болжээ. Энэ нь манай хоёр улсын харилцаа хүмүүнлэгийн салбарт нэвтэрч, хоёр орны олон нийт, боловсрол, шинжлэх ухаан, соёл урлагийн ажилтнууд харилцан зорчиж, бие биенээ түүх соёлоо харилцан танин мэдэх өргөн боломжийг олгосон төдийгүй Монгол, Японы харилцаанд шинэ үеийг эхлүүлсэн гэж үзэж болно. Хоёр орны харилцааг илүү өндөр түвшинд хүргэхийн тулд хоёр орны ард түмэн бие биенээ танин мэдэх хэмжээг

өсгөх, харилцан итгэх уур амьсгал бүрдүүлэхэд соёлын харилцаа гол үүрэг гүйцэтгэсэн юм. Токиод ЭСЯ-аа нээхдээ Монгол Улсын Засгийн газар 1974 оны 2 дугаар сард Японы засгийн газарт хоёр орны соёлын харилцааны талаарх саналыг: соёл, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагаа хөгжүүлэх асуудлыг хоёр орны засгийн газрын эрх бүхий төлөөлөгчийн хооронд хийхээр санал дэвшүүлсэн. Энэхүү саналыг Японы Гадаад Явдлын Яам зөвшөөрч, 1974 оны 7 дугаар сард соёлын хэлэлцээр байгуулах санал тавьжээ. Хэлэлцээрийн төслийг хэд хэдэн удаа солилцож, өөр өөрсдийн бодлогыг илэрхийлж, харилцан тохиролцсоны үндсэн дээр 1974 оны 9 дүгээр сарын 23-нд хоёр орны хооронд соёлын солилцоог өргөтгөн хөгжүүлэх талаар нот бичиг солилцох хэлбэрээр хэлэлцээ байгуулагджээ. Уг нотод:

- “Шинжлэх ухаан техник, соёл урлаг, спортын байгууллагын төлөөлөгчид, дадлага хийгчид, жүжигчид, эрдэмтэн, мэргэжилтэн, оюутан, тамирчид болон соёлын салбарт ажиллаж буй бусад хүмүүсийг солилцох,
- Эрдэм шинжилгээний ажил хамтран хийхэд тус дөхөм үзүүлэх,
- Урлагийн тоглолт, лекц, кино үзвэр, уран бүтээлийн үзэсгэлэн зэрэг соёлын арга хэмжээ зохиох
- Үзүүлэн таниулах, сонсох материал солилцох
- Хоёр талын урьдчилан тохиролцсоны дагуу засгийн газрын байгууллагаас хэвлэн гаргадаг албан ёсны мэдээллийн материал тараах
- Эрдэм шинжилгээний холбогдолтой материал солилцох
- Энэхүү арга хэмжээнүүд нь хоёр орны засгийн газрын бус байгууллагын хооронд соёлын солилцоо зохиоход үл харшилна”(Ц.Батбаяр, 2012:178-179) гэжээ.

“Хэлэлцээрийг хэрэгжүүлэх соёлын харилцааны төлөвлөгөөг хоёр улсын ГЯЯ жил тутам байгуулж, түүнд үндэслэн соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагаа зохион байгуулах болжээ. Тухайлбал, “Японы 6 оюутан, аспирант Монголын их сургуульд ирж, монгол хэл бичиг, утга зохиол судлах мэдлэгээ ахиулж манай орны оюутан Японд очиж япон хэл, түр күрсэд суралцав”(Ц.Батбаяр, 2012:179). Монгол,

Японы хэвлэл мэдээллийнхэн харилцан зорчих нь олширч, хоёр тал харилцан мэдээлэл солилцох нь өссөөр байгаа бөгөөд Японы олон улсад англи хэл дээр өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ үзүүлэгч “NHK WORD” телевиз Ази тивийн олон үндэстнүүдийн тухай бэлтгэн хүргэдэг нэгэн төслийнхөө хүрээнд Монгол улсыг төлөөлж “ARIUNAA SURU” брэндийг сонгон баримтат нэвтрүүлэг хийхээр болжээ.

Түүнээс гадна хоёр орны нийслэлд жилдээ нэг удаа соёлын хамтын ажиллагааны төлөвлөгөөний дагуу кино үзвэр, гэрэл зургийн үзэсгэлэн тус тус гаргадаг байв. Мөн Оосака хотын угсаатны зүйн музейд “... музейн захиргаатай тохиролцон 100.000 ам доллараар монгол гэр, түүний хэрэглэл, хувцас хунар зэргийг худалдсан (Танака.Кацүхико, 2010:27)-аар Монгол үндэстний амьдрал, уламжлал заншлыг харуулах булантай болжээ.

Монголын палеонтологийн үзэсгэлэн 1985-1986 онд Японы 19 хотод гарч, Монголын уран зургийн үзэсгэлэн худалдаа 1980 онд Токио хотод гарч байжээ. Мөн “Япон телевиз”-ээс зохиодог олон улсын хүүхдийн гар зургийн уралдаанд монгол хүүхдийн бүтээл 1985 оноос тогтмол оролцож хүндтэй байр эзэлж ирлээ. “Япон сан” 1977, 1985 онд тус бүр 200 мянган иенийн үнэтэй япон хэл сурах ном хэвлэлийг Монголын дээд сургуулиудад бэлэглэж, багш нарыг Япон оронтой танилцуулж байв. (Ц.Батбаяр, 2012:180). Японы засгийн газрын соёлын буцалтгүй тусламжаар 1985 онд 80 мянган ам.долларын үнэ бүхий лингофоны танхим, 1988 онд 376 мянган ам.долларын үнэ бүхий компьютер сургалтын 20 кабинетийг бэлэглэж (Ц.Батбаяр, 2012:181) байжээ.

1974 онд Япон-Монголын нийгэмлэг байгуулагдсан бөгөөд одоогоор 200 гаруй гишүүдтэй ажилладаг. 1975 оны 9 дүгээр сард Ш.Ивамура тэргүүтэй 5 эрдэмтэн Монголд айлчилж Шинжлэх Ухааны Академи, Хөдөө аж ахуйн институттэй хамтран ажиллахаар тохиролцжээ.

“Японы Монгол судлалын нийгэмлэгийн шугамаар 1975-1977 онд гурван жил дараалан жил бүр 20-иод хоногийн хугацаатай Монголыг судлах эрдэм шинжилгээний экспедицийг илгээн ажиллуулсан нь япон эрдэмтэд БНМАУ-д судалгаа шинжилгээ явуулсан анхны томоохон

ажил байлаа. Экспедицийн бүрэлдэхүүнд Ивамура Шинобу, Шигэо Озава, Накаэ Тошитака, Хагивара Жюнпей, Миаки Такэши, Нагахори Кинзо, Танака Кацухико, Хасуми Харуо нарын нэртэй эрдэмтэд профессорууд оролцож, Монголын түүх, хэл шинжлэл, мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр судалгаа явуулжээ. (Б.Сэржав, 2003:60)

1971 оноос хойш Монголын нийгэм, улс төр, уран зохиолын нилээд ном Японд орчуулагдан хэвлэгдсэн бөгөөд япон хүмүүсийн бичсэн Монгол орны тухай 20 гаруй ном, замын тэмдэглэл хэвлэгджээ.

Хоёр орны иргэд бие биеэ мэдэх, ойлгох нь харилцааны хөгжилд чухал ач холбогдолтойг харгалзаж хүн солилцоо, харилцан айлчлалыг аль болох өсгөхөд хоёр тал, ялангуяа японы тал ихээхэн анхаарч байсан юм. Энэ бодлого чиглэл ч биелэлээ олжээ. “1986 онд Монголоос Японд албан ажил, сургууль курсэд 40 орчим хүн очиж байсан бол 3 жилийн дараа 1989 онд уг тоо 140 болж өссөн” (Ц.Батбаяр, 2012:181) жишээтэй.

Мөн соёлын харилцааны түүхэн үед зүй ёсоор багтах ёстой нэгэн зүйл бол Монгол Японы төвийг Монгол улсад байгуулсан явдал юм. 1999 оны 7-р сард Ерөнхий сайд Кэйзо Обучигийн Монгол улсад хийсэн айлчлалын үеэр “Японы соёлын төв”-ийг Монголд байгуулахаар тохиролцсон нь соёл, боловсрол, сургалтын салбарт онцгой ач холбогдолтой шийдвэр болжээ. Тус төвийг Монгол Улсын Их Сургуулийг түшиглэн байгуулсан бөгөөд монголын ард түмэнд япон орны соёл, хөгжлийн туршлагаас таниулж, менежмент, маркетингийн чиглэлийн төрөл бүрийн мэдээлэл түгээх, сургалт семинар зохион байгуулах, ялангуяа Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжиж байсан тэр үед эдийн засаг бизнесийн ажил эрхлэхэд нэн чухал технологи, ноухау дамжуулах, япон хэлний янз бүрийн түвшний сургалт явуулах зэргээр хоёр орны соёлын болон иргэд хоорондын харилцааг идэвхжүүлэх олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлсээр байна.

### **1990 оноос хойших Монгол-Японы соёлын харилцааны онцлог**

1990 оноос хойших хоёр орны соёлын харилцаа нь 1999 оноос эхэлж соёлын чуулган зохион байгуулах болсноор онцлог юм. 1999, 2000, 2007, 2010 он хүртэл нийтдээ 4 чуулган зохион байгуулжээ.

Чуулганы гол зорилго нь “Монгол улсын соёлын өвийн хадгалалт ба ашиглалт”, “Монголын түүхэн ном судар, баримтын хадгалалт ба ашиглалт”, “Биет ба биет бус соёлын өвийг хамгаалах”, “Монгол-Японы соёлын түншлэл хөгжлийн түүх”, “Монгол орны үлэг гүрвэлийн олдвор, олдворт газруудыг хамгаалан хадгалах”, “Соёлын өвийн сэргээн засварлалт, хадгалалт, хамгаалалт”, “Монголын сүм хийдийн түүхэн товчоо төсөл”, “Монголын археологийн дурсгалууд, тэдгээрийг хадгалж хамгаалах зарим асуудал”, “Нүүдэлчин ардын уран зохиол, хөшөө хадны бичээсийн судалгаа”, “Соёлын менежмент”, “Урлагийн менежмент”, “Музейн менежмент”, “Соёлын өвийн менежмент”, “Орон нутгийн соёл, урлагийн менежмент” зэрэг маш олон асуудлуудыг хэлэлцэж ирсэн.

Монгол-Японы соёлын харилцаа нь төрийн болон хувь хүмүүс, иргэд хоорондын харилцаагаар маш идэвхтэй өргөжиж байна. Тухайлбал “Соёлын салбарын харилцаа нь оюутан, багш нарын солилцооноос эхэлсэн юм. (Шигэо.Озава, 2000:15) Улмаар 1980-аад оноос хоёр тал харилцан хүн сургаж эхэлсэн нь хоёр орны харилцаанд гарсан бас нэг чухал дэвшил юм. Японы засгийн газрын буцалтгүй тусламжаар байгуулагдсан “Говь” үйлдвэрт ажиллах хүмүүсийг сургах, залуучуудад дээд боловсрол олгоход үзүүлсэн тусламж нь энэ салбар дахь хамтын ажиллагааны эхлэл байжээ. Ийнхүү 1980-аад оны дунд үеэс Японд дээд боловсрол эзэмшсэн, судалгаа шинжилгээний ажил хийсэн, хамтын судалгааны төсөлд оролцсон монголчуудын тоо улам бүр нэмэгдэж, хоёр орны соёлын салбарын хамтын ажиллагаа улам өргөжсөн байна.

Монгол-Японы соёлын харилцаа шинэ агуулга хэлбэрээр баяжиж сүүлийн жилүүдэд урлагийн хамтлаг, үзэсгэлэн солилцох, аялал жуулчлалаас эхлээд соёл, шинжлэх ухаан, боловсрол хүмүүнлэгийн болоод эдийн засаг, бизнесийн хүрээг хамарсан өдрүүдийг хоёр оронд байнга зохиодог болтлоо өргөжин тэлсэн юм. 1998 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн Япон улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр гаргасан “Найрамдал, хамтын ажиллагааны хамтарсан мэдэгдэл”-д хоёр орны харилцааг XXI зуунд “иж бүрэн түншлэл”-ийн хэмжээнд өргөжүүлэн хөгжүүлэх үндсэн зарчмыг тодорхойлон үүнээсээ өсөж хөгжсөөр “стратегийн түншлэл”-д хүртлээ хоёр орны

харилцаа жил ирэх тусам ахин дэвжсээр байгаа юм.” (Р.Бат-Эрдэнэ, 2000:23)

Хоёр орны харилцаа нь хоёр талын шууд хамтын ажиллагаанаас гадна олон улсын байгууллагуудын хүрээнд ч идэвхтэй явагдаж байна. Тухайлбал, түүх дурсгалыг сэргээх, хамгаалах боловсролын салбарын шинэчлэлийг дэмжих чиглэлээр “ЮНЕСКО”, “Азийн хөгжлийн банк”-ны шугамаар Монголд хэрэгжиж буй олон төсөл, хөтөлбөрийн санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч нь Японы Засгийн газар, байгууллага байдгийг дурьдах нь зүйтэй юм.

“Монгол, Японы боловсролын салбар дахь хамтын ажиллагааны хүрээнд Монголын ерөнхий боловсрол 10 жилийн сургалтаас дэлхийн стандартад нийцэн 12 жилийн тогтолцоотой болсон. Манай орны их сургуулиуд төдийгүй ерөнхий боловсролын зарим сургуулиуд японы түншүүдтэйгээ янз бүрийн хэлбэрээр харилцаж байна. Тухайлбал, тодорхой мэргэжлээр хамтарсан сургалтын хөтөлбөр боловсруулж оюутан, багш, судлаач солилцох, японы их сургуулиуд, коллежийн салбарыг Монголд нээн, Японы хөрөнгө оруулалттай сургууль байгуулах ажлыг хэрэгжүүлэн, монголын залуучуудыг илүү өргөнөөр, харьцангуй хямд зардлаар эх орондоо өндөр боловсрол эзэмших нэмэлт боломжоор хангаж байна. Манай боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагууд 1980-аад оноос хойших хугацаанд Япон Улсаас буцалтгүй тусламж авч, боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагуудад шинэ техник, технологи, тоног төхөөрөмж, нэвтрүүлэх, сургалт, судалгааны баазыг бэхжүүлэх, янз бүрийн наадам, уралдаан тэмцээн зохиох зэрэг төсөл, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж (Ж.Уянга, 2007:113) иржээ. Сүүлийн жилүүдэд Монгол, Японы хамтын ажиллагаа өргөжин урлагийн хамтлагууд, багш, оюутан сурагч солилцох талаар томоохон ахиц гарч байна.

Мөн хоёр орны төрийн бус байгууллагууд болон аймаг, муж, сум, хотуудын шууд харилцаа өргөжиж, өдгөө Төв аймаг Тоттори мужтай, Хөвсгөл аймаг Шига мужтай, Өвөрхангай аймгийн Хужирт сум Нагасаки мужийн Такашима тосгонтой, Баянхонгор аймгийн Богд сум Хёго мужийн Танто тосгонтой тус тус хамтын ажиллагаатай байна. Чухамхүү ийм хэлбэрийн хамтын ажиллагаа нь хүмүүсийн хооронд нөхөрсөг хэлхээ холбоо үүсгэж байгаагаараа маш үнэ цэнэтэй юм.

Мөн “Монгол дахь Японы жил”-ийг зохион байгуулах Хороо, ШУА-ын Олон Улс Судлалын Хүрээлэн, Монгол Улс дахь Япон улсын ЭСЯ, Монгол-Японы төвөөс хамтран “Монгол дахь Япон судлал” сэдэвт симпозиумыг 2007 оны 1-р сарын 19-ний өдөр Улаанбаатар хотноо Монгол-Японы төвд зохион байгуулсан. (Ж.Уянга, 2007:113) Мөн энэ үеэр хоёр орны харилцааны 45 жилийн түүхийг өгүүлэх гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгуулагджээ. Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам нь Япон Улс, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ойг тохиолдуулан Япон Улсын үндэсний хувцас болох кимоног уламжлалт болон орчин цагийн өөр өнцгөөс танилцуулах “UB Kimono Fashion Show – Tradition & Modernity” арга хэмжээг зохион байгуулжээ.

**Монгол - Японы хоорондын боловсрол, соёл,  
шинжлэх ухааны хамтын ажиллагаа**

Соёлын чуулган зохион байгуулсан цагаас өнөөг хүртэл хугацаанд хоёр орны соёлын олон талт хамтын ажиллагаа улам бүр хөгжсөөр байна.

“Манай орны хувьд соёлын биет болон биет бус өвийг хамгаалах асуудал нь хоёр орны харилцааны бас нэгэн салшгүй хэсэг юм. ЮНЕСКО болон Япон, Хятад, Турк зэрэг хөгжингүй орнууд, олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудын зүгээс манай оронд материал санхүү, арга зүй, зохион байгуулалтын бүх хэлбэрээр үзүүлж байгаа тусламж нь соёлын биет болон биет бус өвийг хамгаалах нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэхэд маш чухал үүрэг гүйцэтгэж байгаа билээ. Манай улс 1990 оноос хойших хугацаанд ЮНЕСКО-гийн 4 конвенци, түүний дотор “Биет бус соёлын өвийн конвенци”-д нэгдэн орсны дээр Монгол ардын уртын дуу, морин хуурын уламжлалт урлаг, мөн Орхоны хөндийн түүх, соёлын дурсгалт газрыг дэлхийн биет болон биет бус соёлын өвийн шилдэг дээжээр бүртгүүлэн, ЮНЕСКО-гийн батламж хүлээн авсан байна”. (С.Төмөр-Очир, 2007:22) Японы Засгийн газрын тусламжтайгаар монголын Соёлын өвийн төвийг орчин үеийн дүрс бичлэг, гэрэл зургийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, сэргээн засварлах багаж хэрэгслээр тоногложноор монголын соёлын өвийн бүртгэл-мэдээллийн санг технологийн шинэ

түвшинд бүрдүүлэн бүртгэх болон сэргээн засварлах боломж нээгдсэн юм.

Мөн “Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Японы “Ёмиүри” сонин тэргүүлж 1990-1993 онд Монгол-Японы хамтарсан Их эзэн Чингис хааны онгоныг эрж хайх “Турван гол” төсөл хэрэгжүүлжээ. Археологийн хэсгийг профессор Д.Цэвээндорж, профессор Ш.Като нар удирдан судалгаа явуулж 1990-1992 онд 40000 км (дэлхийн бөмбөрцгийн бүслүүртэй тэнцэхүйц) зам туулж, 3586 булш, бунхан, суурины үлдэгдэл зэрэг археологийн дурсгалыг бүртгэж, байршил, тодорхойлолтыг хийсэн нь хоёр орны эрдэмтдийн хамтарсан судалгааны цар хүрээг харуулж байгаа юм. ...Хэнтий аймгийн Баянхутаг сумын нутагт Сэрвэн хаалга гэдэг газрын хаднаас урьд мэдэгдэж байсан зүрчид бичээсийн зэрэгцээ хятад бичээс шинээр нээж олсон нь эрдэм шинжилгээний чухал нээлт болжээ. Тэрхүү хятад бичээс нь урьд мэдэгдэж байсан зүрчид бичээснээс зүүнтэй 18 метр зайтай 3м өндөр, 4м өргөн хаданд 9 мөрөөр бичсэн ба хадны бичигтэй өнгөн хэсгийн нилээд нь ховхорч унасан тул олон үсгийг тайлж унших боломжгүй болжээ. Уг бичээсний 8 дугаар мөрөнд “Мэй-шүгийн 7-дугаар он” гэсэн тод үсэг үлджээ. Энэ нь Алтан Улсын Татарыг дайлсан “Мэй-шүгийн 6-р он буюу 1195 оны тулалдааны дараа энэ бичээсийг сийлсэн” гэсэн дүгнэлтэнд хүргэжээ. (Д.Цэвээндорж, 2008:71)

Сэрвэн хаалганы бичээсэнд Чингис хаан монгол угсаатныг нэгтгэх явцдаа болон дайснаа дарахын тулд бусадтай хүч хавсарсан тухай өгүүлсний зэрэгцээ түүхийн сурвалжийн бусад мэдээтэй тохирч буй зэрэг олон талаасаа эдгээр бичээс нь Чингис хааны түүх болон Монголын Нэгдсэн Улс байгуулах үеийн түүхийн чухал дурсгал болно.

Монгол, Японы археологчид “Буган хөшөө” төслийг Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутаг Уушгийн өвөрт орших хүрэл зэвсгийн үеийн олон тооны буган хөшөө бүхий цогцолбор дурсгалыг малтан шинжлэх ажлыг амжилттай хэрэгжүүлсэн байна.

2001-2007 онд Монголын Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэн, Японы Нийгата Их Сургуультай хамтран “Шинэ зуун” эрдэм шинжилгээний төслийг хэрэгжүүлсэн байна. Энэхүү төслийн хүрээнд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг

Хэрлэнгийн хөдөө аралд орших Чингис хааны “Аураг” ордны туурийг судлах, хадгалж, хамгаалахын зэрэгцээ Баянхутаг, Баянмөнх сумдын нутагт буй зарим түүх, соёлын дурсгалыг судлах зорилготой ажиллажээ. Судалгааны ажлын үр дүнд Аураг хотын тууринд 3 өөр цаг үед холбогдох давхар барилгын тууриудыг илрүүлж, шинэ мэдээллүүд олж авсан болон тус төсөлд оролцогчдын санал, тодорхойлолтоор Монгол Улсын Засгийн газрын 2003-оны 190-р тогтоолоор Аураг ордын туурийн хамгаалалтын бүсийг тогтоосон нь чухал алхам болжээ.

Монголын Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэн, Японы Саппора хотын Гакуин Их сургуультай хамтарсан “Дорнод Монголын палеолитын судалгаа”-ны хүрээнд Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Рашаан хад хэмээх газар чулуун зэвсгийн суурингийн хоёр газарт туршилтын малтлага хийсэн бөгөөд цаашид төсөл хэрэгжүүлэх объект, дурсгалыг сонгох зорилготой. Уг ажил нь 1980-1981 онд МЗТСХЭ-ийн Чулуун зэвсгийн дурсгал судлах ангийн хийсэн судалгааны зарим дүгнэлтийг газар дээр нь нягтлан хамгийн доод соёлт давхаргын зааг үеийн талаар илүү мэдээлэл олгожээ. Мөн “1996-1998 онд Монгол-Японы хамтарсан “Бичээс” төслийн хүрээнд манай улсын нутагт орших монгол, түрэг, хятад, түвд бичээс судлах ажлыг амжилттай хэрэгжүүлж Эрдэнэ зуу хийдийн хэрмэн хана болон сүмийн барилгын материал болгон ашигласан 10 орчим монгол болон хятад бичигтэй хөшөөг илрүүлэн олжээ. (Д.Цэвээндорж, 2008:73)

“1995-1997 онд ЮНЕСКО-гийн шугамаар Монгол, Японы судлаачид Д.Цэвээндорж, Ш.Като нарын удирдлагаар Их Монгол Улсын нийслэл Хархорум хотын хилийг тогтоох, археологи геофизикийн судалгаа хийж дэвсгэр зургийг үйлдэх төслийг амжилттай хэрэгжүүлсэн төдийгүй хамгаалалтын хашаа барьж өгчээ. (Д.Цэвээндорж, 2008:75)

2006-2007 онд Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэн, Японы судлаачидтай хамтарсан “Бичээс” төслийг Төв, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Булган аймагт хэрэгжүүлсэн.

Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэн, Японы Саппорогийн Их сургуультай хамтарсан “Чинтолгой” төслийг 2007 онд Булган аймгийн Дашинчилэн суманд зохион байгуулжээ.

Мөн Япон улс бол Монголын аялал жуулчлалын салбарын хувьд онцгой ач холбогдолтой, гол зах зээлийн орон юм. 2010 онд Монголд нийт 557414 жуулчин зочилсны 14369 нь Япон улсын иргэд байсан байна. Энэ нь өмнөх оноос 26 хувиар өссөн үзүүлэлт юм. Монгол орны онгон байгаль, нүүдлийн соёл ахуй нь аялал жуулчлалын гол нөөц учраас энэ салбарыг хөгжүүлэхдээ байгаль орчин, нийгэм, соёлд үзүүлэх сөрөг нөлөөллийг харгалзан эко аялал хөгжүүлэх нь чухал байгаа юм. Энэхүү аяллыг Монголд хөгжүүлэхэд Япон улс хамгийн идэвхтэй дэмжиж, хамтран ажиллаж байгаа билээ. 2010 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн япончууд Монгол Улсад 30 хоногийн хугацаатайгаар визгүй зорчих эрхтэй болсон нь Япон Улсаас манай оронд ирэх аялагчдын тоог нэмэхэд өндөрөөр нөлөөлсөн юм.

### ***ДҮГНЭЛТ***

1972 онд Монгол Япон Улс дипломат харилцаа тогтоосон. Монгол Улс социалист орон байсан тул үзэл суртал, нийгмийн байгууллын ялгаанаас хамааран хамтын ажиллагаа өргөжих бололцоо хязгаарлагдмал байсан ч Япон улстай харилцах харилцаа аажмаар тогтвортойгоор хөгжиж байна. Монголд ардчилал хөгжсөнөөс хойш хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа өргөжин гүнзгийрч, 1990-ээд оноос эхлэн маш олон гэрээ хэлэлцээр хийгдэн, мөн Монгол Улсын хөгжлийг дэмжих тусламжийн хөтөлбөрүүд хэрэгжиж эхлэн, улмаар 2007 онд “иж бүрэн түншлэл”, 2010 онд “стратегийн түншлэлийн харилцаатай болсон юм.

Япончууд манай улсын боловсролын салбарт түлхүү суурилж дээрх харилцааг өргөжүүлдэг. 1976 онд анхны монгол оюутныг судлаач оюутнаар хүлээн авснаар боловсролын салбарт соёлын харилцаа эхэлж 1980-оос илүү идэвхжиж ирсэн. Түүнээс хойш жил болгон нэгээс хоёр оюутан хүлээн авдаг байсан бол Монгол улс ардчилаас хойш хоёр орны соёлын харилцаа огцом хурдацтай хөгжсөнөөр монгол оюутны тоо эрс өссөн байна. Жил бүр Япон улсын засгийн газрын тэтгэлэг болон бусад тэтгэлэг, хөтөлбөрүүд зохион байгуулагдан маш олон оюутан залуучууд Япон улсыг зорих болсон. Манай хоёр улс ерөнхийдөө эдийн засаг, бүтээн байгуулалт, соёл боловсрол талаараа

илүү хамтарч ажилладаг. Мөн Монгол Улс нь түүхэндээ анх удаа Япон улстай эдийн засгийн түншлэл байгуулсан юм.

### **НОМЗҮЙ**

Ашигласан номын жагсаалт

1. Баатар Ц. “Японы хөрөнгө оруулалт, зээл, тусламж түүний үр ашиг” УБ., 2004
2. Бадрал.Н “Монгол, Японы дипломат харилцааны хөгжлийн үечлэл” УБ., 2011
3. Батбаяр Ц. “Монгол ба Япон XX зуунд” УБ., 2012
4. Монгол-Японы соёлын чуулга №3, УБ., 2008
5. Сэржав Б. “Монгол, Японы харилцаа XX зууны сүүлийн хагаст” УБ., 2003
6. Хайсандаа Л. “Монгол-Японы эрт эдүгээ” УБ., 1998
7. Хайсандаа.Л. “Монгол-Японы харилцаа: эерэг хандлага өөдрөг үйл явц”. УБ., 1998
8. Танака Кацүхико. “XX зууны Япон-Монголын харилцааны түүхээс”. Монгол-Японы харилцаа: Өнгөрсөн ба Эдүгээ (XX зуун) УБ., 2010

Ашигласан сэтгүүл, сонин, тэмдэглэл:

1. Бат-Эрдэнэ.Р. “Монгол-Японы шинжлэх ухаан, боловсрол, соёлын хамтын ажиллагаа XXI зуунд”. Япон-Монголын соёлын чуулган УБ., 2000
2. Гадаад Харилцааны Төв Архив “Ярианы тэмдэглэл”. №3
3. Гадаад Харилцааны Төв Архив “Ярианы тэмдэглэл”. №14
4. Гадаад харилцааны төв архив “Ярианы тэмдэглэл” №25
5. Монгол-Японы харилцаа: Өнгөрсөн Эдүгээ (XX зуун) Олон Улсын Эрдэм Шинжилгээний III хурал, УБ., 2010
6. Олон Улс Судлалын Сэтгүүл №2, УБ., 2001
7. Олон Улс Судлалын Сэтгүүл №1, УБ., 2007

8. Өдрийн сонин 2016.2.17
9. Сэржав Б. “Монгол Японы байгаль орчны салбарын хамтын ажиллагаа”. “XXI зууны Монгол Японы стратегийн түншлэл: Байгаль орчин, Эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагаа” (судалгааны өгүүллийн эмхэтгэл) УБ., 2016
10. Сэржав Б. “Монгол Улс, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосон нь”. Олон Улс Судлалын сэтгүүл №2, УБ., 2001
11. Уянга.Ж. “Монгол дахь Япон судлал симпозиум” Олон Улс Судлал Сэтгүүл №1 УБ., 2007
12. Төмөр-Очир.С. “Соёлын биет, биет бус өвийг хамгаалах зарим асуудлууд”. Монгол-Японы соёлын чуулган №3 УБ., 2007
13. Цэвээндорж.Д. “Монголын Археологийн Судалгаа”. Монгол-Японы соёлын чуулган, УБ., 2008
14. Шигэо Озава. “Япон-Монголын соёлын харилцаа”. Япон-Монголын соёлын чуулган УБ., 2000
1. Цахим эх сурвалж:
15. [www.mn.emb-japan.go.jp](http://www.mn.emb-japan.go.jp)
16. [www.mfa.gov.mn](http://www.mfa.gov.mn)